



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар

17266

Улаанбаатар хот

Багануур дүүргийн 193 дугаар
цэцэрлэгийн хөрөнгө данснаас дансанд
шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 09 дүгээр сарын 17-ний өдрийн 8 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 890,000.00 (найман зуун ерэн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Багануур дүүргийн 193 дугаар цэцэрлэг (Б.Энхзаяа)-т зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Багануур дүүргийн 193 дугаар цэцэрлэг (Б.Энхзаяа)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500348

Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны
 ... дугаар сарын ... ны өдрийн дугаар тушаалын хавсралт



Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багануур дүүргийн 193-р цэцэрлэг

№	Хөрөнгийн нэр	Марк дугаар	Үйлдвэр лэсэн он	Ашиглал тад авсан он	Чанар байдал	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ		Хуриятлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Дансны нэр	
								Нэгж үнэ	Нийт үнэ			шилжүүлэх Данс	бүртгэх данс
1	Өнгөт принтер	Epson L3110	2020	2020	дунд	ш	1	420,000.00	420,000.00	-	420,000.00	хангамжийн материал	машин, тоног төхөөрөмж
2	Теннисний ширээ		2020	2020	дунд	ш	1	470,000.00	470,000.00	-	470,000.00		тавилга, эд хогшил
Нийт хөрөнгийн дүн								890,000.00	890,000.00		890,000.00		